



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хүмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр тогтоол, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндэсэн чиглэл, Нийслэлийг Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон тус газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор хотын стандартын баримт бичгийг боловсруулах зөвлөх үйлчилгээ, стандарт, норм дүрмийн судалгаа хийх болон бусад ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Ариунзаяа)-ийн худалдан авах ажиллагааны 2019/АЗ-4242 дугаартай сертификатны хүчинтэй хугацаа 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөр дууссан тул нарийн бичгийн даргын ажлаас чөлөөлөн, Хотын хөгжлийн стандартын хэлтсийн мэргэжилтэн (Б.Биндэръяа)-г үнэлгээний хорооны нарийн бичгээр, Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн (О.Өнөрбилэг)-ийг үнэлгээний хорооны гишүүнээр тус тус томилсугай.

3.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллахыг Үнэлгээний хороо (О.Оджаргал)-нд даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны А/30 дугаар тушаалын гуравдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150500172

Газрын даргын 2022 оны 9 дүгээр
сарын 14-ний өдрийн 11/11 дугаар
тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга:

О.Оджаргал

(Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн
даргын үүрэг гүйцэтгэгч)

Гишүүд:

Э.Даваахатан

(Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга)

Г.Амартүвшин

(Байгаль, орчны стандартын хэлтсийн Ахлах
мэргэжилтэн)

Г.Бүтэнбаяр

(Хот, нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн
мэргэжилтэн)

О.Өнөрбилэг

(Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн)

О.Бат-Амгалан

(Сонгинохайрхан дээрхийн 31 дүгээр хороо,
Хайрханы 3-87 тоотод оршин суугч)

Нарийн бичгийн дарга:

Б.Биндэръяа

(Хотын хөгжлийн стандартын хэлтсийн
мэргэжилтэн)